



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/1997

Мандалговь

Эзэмшил газрын зориулалт өөрчилж,
нэгж талбарыг нэгтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.1.3.1, 5.1.3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Худалдааны 2-224г тоот) байршилтай иргэн Осорын Ганбаатар (ХЙ72040271)-ын нийтийн орон сууцны зориулалттай 592 м.кв (0.05 га) газар, (Худалдааны 2-224в тоот) байршилтай автомашины гаражын зориулалттай 85 м.кв (0.0085 га) газар, (Худалдааны 2-203а тоот) байршилтай автомашины гаражын зориулалттай 68 м.кв (0.0068 га) гаазр, (Худалдааны 2-224б тоот) байршилтай автомашины гаражын зориулалттай 72 м.кв (0.0072 га) газрыг нэгтгэж 817 м.кв (0.08 га) болгон 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтаар нь 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сайнцагаан сумын Засаг дарга бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/197 тоот захирамж, 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/218 тоот захирамж, 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/158, А/159 тоот захирамжуудын О.Ганбаатарт холбогдох хэсэг мөн газар эзэмших эрхийн 0000072308, 0000072255, 0000061087, 0000060981 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



4822100728